


3 онооны бодлогууд:

1) Дараах тоонуудын аль нь тэгш тоо вэ?

- A) 2009 B) $2 + 0 + 0 + 9$ C) $200 - 9$
 D) 200×9 E) $200 + 9$

2) Кенгуру хаана байгааг олоорой. (Зураг хар)

- A) Тойрог ба гурвалжины дотор, квадратын гадна
 B) Тойрог ба квадратын дотор, гурвалжны гадна
 C) Гурвалжин ба квадратын дотор, тойргийн гадна
 D) Тойргийн дотор, гурвалжин ба квадратын гадна
 E) Квадратын дотор, тойрог ба гурвалжны гадна



3) 19,03 ба 2,009 тоонуудын хооронд хэдэн бүхэл тоо байгаа вэ?

- A) 16 B) 17 C) 14 D) 15 E) 17 –оос их

4) Самбар дээр хоёр тоог нэмсэн байна. Тэгвэл *-ын оронд ямар цифр байх вэ?

- A) 2 B) 4 C) 5 D) 7 E) 8



5) Цагаан, улаан, ногоон гэсэн гурван хайрцаг байжээ. Тэдний нэгэнд нь шоколад, нөгөөд нь алим, үлдсэн нь хоосон байв. Хэрэв цагаан, улаан хайрцагны аль нэгэнд нь шоколад байгаа, цагаан, ногоон хайрцагны алинд нь ч алим байхгүй гэдэг нь мэдэгдэж байвал шоколад аль хайрцагт байгааг ол.

- A) цагаан B) улаан C) ногоон
 D) улаан эсвэл ногоон E) тодорхойлох боломжгүй

6) Энэ биет (нүхтэй призм) хэдэн талстай вэ? (Зураг хар)

- A) 3 B) 5 C) 6 D) 8 E) 12



7) 120 метр өргөн гол дээгүүр гүүр барьжээ. Гүүрний дөрөвний нэг хэсэг нь голоос баруун тийш, дөрөвний нэг хэсэг нь голоос зүүн хэсэгт барьсан бол гүүрний уртыг ол.

- A) 150 м B) 180 м C) 210 м D) 240 м E) 270 м


8) Өрөөнд хэсэг муур, нохой байжээ. Муурнуудын хөлийн тоо, нохойны сүүлний тооноос хоёр дахин их бол муурны тоо

- A) нохойноос хоёр дахин их B) нохойны тоотой тэнцүү
C) нохойноос хоёр дахин бага D) нохойны тооны дөрөвний нэгтэй тэнцүү
E) нохойноос дөрөв дахин их
байна.

4 онооны бодлогууд:


9) Цифрүүдийг шүдэнзээр хэрхэн дүрслэхийг зурагт үзүүлэв. Тэгвэл хамгийн их шүдэнз орсон хоёр оронтой тоонд хэдэн шүдэнз хэрэгтэй вэ?

- A) 10 шүдэнз
B) 11 шүдэнз
C) 12 шүдэнз
D) 13 шүдэнз
E) 14 шүдэнз




10) Дараах олснуудын аль нь нэгээс олон олсноос тогтсон байна вэ?

- A) 1, 3, 4 ба 5 B) 3, 4 ба 5
C) 1, 3 ба 5 D) бүгд
E) аль нь ч биш



11) Талууд нь $AB = 11\text{ м}$, $BC = 7\text{ м}$, $CD = 9\text{ м}$, $DA = 3\text{ м}$ ба A ; C өнцгүүд нь тэгш байх $ABCD$ дөрвөн өнцөгтийн талбайг ол.

- A) 30 см^2 B) 44 см^2 C) 48 см^2
D) 52 см^2 E) 60 см^2



12) Бүжгийн дугуйлан 39 хүү, 23 охинтой байв. Долоо хоног бүр хөвгүүдийн тоо 6-аар, охидын тоо 8-аар нэмэгддэг. Хэдэн долоо хоногийн дараа охид ба хөвгүүдийн тоо тэнцүү болов. Тэгвэл дугуйланд энэ үед хэдэн охид, хөвгүүдтэй болсон бэ?

- A) 144 B) 154 C) 164 D) 174 E) 184

13) Цамхаг нь квадрат, тэгш өнцөгт, адил талт гурвалжин хэлбэртэй гурван дүрсээс тогтоно. Гурван дүрсийн периметрууд нь тэнцүү ба квадратын тал нь 9 см. Тэгвэл тэгш өнцөгтийн талын урт хэд вэ? (Зураг хар)



- A) 4 см B) 5 см C) 6 см D) 7 см E) 8 см

14) Бүтэн сайн өдрөөс эхлэн Болд 290 хуудастай ном уншиж эхлэв. Тэр бүтэн сайн өдөр бүр 25, бусад өдрүүдэд 4 хуудас уншдаг. Болд энэ номыг хэдэн өдөр уншсан бэ?

- A) 5 B) 46 C) 40 D) 35 E) 41

15) Гүйлтийн тэмцээнд Амар, Бат, Вандан, Гомбо нар эхний дөрвөн байр эзэлжээ. Амар, Бат, Гомбо гурвын эзэлсэн байрыг нэмбэл 6 гарна. Бат, Вандан хоёрын эзэлсэн байрыг нэмбэл мөн 6 гарна. Хэрэв Бат нь Амараас дээгүүр байр эзэлсэн бол хэн нь түрүүлсэн бэ?

- A) Амар B) Бат C) Вандан D) Гомбо
E) тодорхойлох боломжгүй

16) Тэнцүү хэмжээтэй 18 ширхэг квадратыг авч тал талаар нь нийлүүлэн нэг бүтэн тэгш өнцөгт хийжээ. Тэгвэл хэдэн ширхэг ялгаатай тэгш өнцөгт хийж чадах вэ?

- A) 1 B) 2 C) 3 D) 5 E) 10

17) Молом А гэсэн эерэг бүхэл тооны дөрвөн шинжийг хэлэв.


- 1) 3-д хуваагдана. 2) 4-д хуваагдана.
3) 12-т хуваагдана. 4) 4-өөс бага.

Дээрх дөрвөн шинжийн хоёр нь үнэн, хоёр нь худал бол А тоо хэд вэ?

- A) 1 B) 3 C) 4 D) 6 E) 12

5 онооны бодлогууд:

18) 6 гурвалжин нүүртэй (талстай) биет өгчээ. Түүний орой бүр дээр 1 эсвэл 5 гэсэн тоо байрлана. Нүүр бүрийн орой дээрх тоонуудын нийлбэрүүд нь тэнцүү. Тэгвэл биетийн таван орой дээр байрласан тоонуудын нийлбэр хэд вэ? (Зураг хар)




- A) 9 B) 12 C) 17 D) 18 E) 24

19) Зочид буудал 5 давхар ба давхар бүр 35 өрөөтэй. Нэгдүгээр давхрын өрөө нь 101-ээс 135 хүртэл дугаартай. Мөн үүний адилаар хоёрдугаар давхар нь 201-ээс 235, гуравдугаар давхар нь 301-ээс 335, дөрөвдүгээр давхар нь 401-ээс 435, тавдугаар давхар нь 501-ээс 535 хүртэл дугаартай. Тэгвэл эдгээр өрөөнүүдийг дугаарлахад 2 гэсэн цифр хэдэн ширхэг орсон бэ?

- A) 60 B) 65 C) 95 D) 100 E) 105

20) ABCD квадратын тал нь 10 см. N ба M цэгүүдийн хоорондох зай 6 см. (Зураг хар) Тэгвэл зурааслагдсан дүрсийн талбайг ол.




- A) 42 cm^2 B) 46 cm^2 C) 48 cm^2 E) 58 cm^2 D) 52 cm^2

21) Зурган дээр байгаа ■▲● дүрсүүдэд нэг нэг тоо харгалзана. Мөн зурагт мөр ба багана бүрийн дүрсүүдэд харгалзах тоонуудын нийлбэрийг бичжээ. Тэгвэл ■+▲-●-д харгалзах тоон утгыг ол.

| | | | |
|----|---|---|----|
| ■ | ● | ■ | 11 |
| ● | ■ | ▲ | 8 |
| ● | ▲ | ■ | 8 |
| 10 | 8 | 9 | |


- A) 2 B) 3 C) 4 D) 5 E) 6

22) Кенгуру А нүдэнд байх бүхэл тооноос эхлэн бодно. Тэр сумны дагуу явахдаа харгалзах үйлдлийг хийж шилжинэ. В нүдэнд очиход 2009 гардаг байх хэдэн зам байна вэ?



- A) Гурван зам байна.
 B) Ижил тооноос эхэлсэн хоёр зам байна.
 C) Ялгаатай тооноос эхэлсэн хоёр зам байна.
 D) Зөвхөн нэг зам байна.
 E) Тийм боломжгүй.

23) Даалуу 28 модтой ба мод бүр нь хоёр хэсэгтэй. Хэсэг бүрт 0 – 6 хүртэл нүхтэй. Хэрэв аль ч хоёр мод нь ижил хоёр хэсэггүй бол энэ даалуу нийт хэдэн нүхтэй вэ?




- A) 84 B) 105 C) 126 D) 147 E) 168

24) Эхний мөрөнд нь тоо бичсэн хоёр баганаас тогтох хүснэгт байв. Хоёрдугаар мөрөөс эхлэн, мөрөнд бичигдсэн тоог өмнөх мөрийн нийлбэр ба ялгавраар тодорхойлно. (жишээлбэл 4×2 гэсэн хүснэгтийн зурагт үзүүлэв). Тэгвэл 7×2 хүснэгтийн 7-р мөрөнд 96 ба 64 гэсэн тоонууд бичигдсэн бол эхний мөрөнд байгаа тоонуудын нийлбэрийг ол

| | |
|----|----|
| 10 | 3 |
| 13 | 7 |
| 20 | 6 |
| 26 | 14 |

- A) 8 B) 10 C) 12 D) 20 E) 24

25) Дүрсийн нүд бүрийг A, B, C, D гэсэн дөрвөн өнгөөр ерөнхий оройтой нүднүүд нь ижил өнгөгүй байлгаж будахаар төлөвлөв. (Аль нэг орой нь давхцаж байгаа нүднүүдийг ерөнхий оройтой гэнэ). Тэгвэл эхний удаа зурагт үзүүлсэнээр будсан бол баруун доод булангийн нүд ямар өнгөтэй вэ?



- A) A B) B C) C D) D E) тодорхойлох боломжгүй